



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 02 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

**Халаалт, хэрэглээний халуун усны  
шугамыг шинэчлэх ажил (БХД, 1 дүгээр хороо)-ын  
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, 47 дугаар зүйл, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1142 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд “Халаалт, хэрэглээний халуун усны шугамыг шинэчлэх ажил (БХД, 1 дүгээр хороо)”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны

дарга: Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын Тохижилт,  
худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга  
Багахангай гэрэлтүүлэг, ногоон  
байгууламж ОНӨААТҮГ-ын захирал  
Илч-Орд ОНӨААТҮГ-ын нярав  
1 дүгээр хорооны иргэн

Гишүүд: Ч.Батхуяг

Б.Алтантүлхүүр  
Д.Баасанжав

Нарийн бичиг

Д.Амгалан

Худалдан авах ажиллагааны албаны  
Ахлах мэргэжилтэн

2.Хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Үнэлгээний хороо (Д.Хүрэлбаатар)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД